



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/50

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Шадар сайдтай, аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээ, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааг зохион байгуулах төлөвлөгөө, шаардагдах зардлыг 1 дүгээр хавсралтаар, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус арга хэмжээнд шаардагдах зардал 24994691/хорин дөрвөн сая есөн зуун ерөн дөрвөн мянга зургаан зуун ерөн нэг/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн гамшигтай тэмцэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.


4. Дээрх арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу сахилга хариуцлага чанарын өндөр түвшинд зохион байгуулж дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга /Онцгой байдлын хурандаа Д.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны 02
дугаар сарын 08 өдрийн 7/50 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Чанцал	-Онцгой байдлын газрын орлогч , урьдчилан сэргийлэх тасгийн дарга
Гишүүд	Х.Наранхүү	-Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Н.Анхбаяр	-Хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн албаны дарга
	Ж.Отгонбаяр	-Цагдаагийн газрын нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга